


EDMONDS COLLEGE ХЯЗГААРГҮЙ БОЛОМЖУУДААР ДҮҮРЭН!

- Манай **ахлах сургуулийн хөтөлбөр**-ийг бүрэн эзэмшсэнээр коллежийн кредит цуглуулахын зэрэгцээ ахлах сургуулийн дипломтой төгсдөг.
- Манай **Англи хэлний институт** нь англи хэлний мэдлэгийг тань тэлж улмаар таныг эрдмийн их үйлс, ажил мэргэжлийн гараанд бэлтгэх болно.
- Манай **хоёр жилийн солилцоо**-ны хөтөлбөрийн зэрэг нь дэлхийн шилдэг их сургуулиудад элсэн суралцах замыг танд нээж өгөх болно!
- Бид **мэргэжлийн** зэрэг, **гэрчилгээ** мөн **Хэрэглээний шинжлэх ухааны бакалаврын** таван зэргийг олгодог 120 гаруй чиглэлээр суралцах боломжийг олгодог!

ТРИТОН БОЛОХ ХЯЛБАР АЛХМУУД

- Онлайн өргөдөл ирүүлнэ.
- Англи хэлний түвшин тогтоохоноог ирүүлнэ. Оюутнууд манай англи хэлний түвшин тогтоох шалгалтыг үнэ төлбөргүй онлайнаар өгөх эсвэл манай Англи хэлний институтэд суралцах хүсэлт гаргах боломжтой.
- Нэг жилийн хөтөлбөрийн хамгийн бага зардалтай тэнцэхүйц хэмжээний үнийн дүнгийн үлдэгдэлтэй болохыг батлан харуулсан банкны одоогийн тодорхойлолтыг ирүүлнэ. Тооцоолсон зардлуудыг доороос үзнэ үү!
- Буцаан олгогдохгүй өргөдлийн хураамжид 50 ам.доллар төлнө.
- Ахлах сургуулийн төгсөх хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаж байгаа бол гадаад паспорт болон ахлах сургуулийн дүнгийн хуулбарыг англи хэлээр ирүүлнэ.



Өргөдөл, англи хэлний шалгалтын оноо болон бусад шаардлагатай мэдээллийг авах бол энэхүү QR кодыг уншуулна уу!

ЗАРДАЛ

Зардал	Коллеж ба Ахлах сургууль		Бакалаврын зэрэг		Англи хэлний институт (АХИ)	
	1 жил (3 улирал)	1 улирал (3 сар)	1 жил (3 улирал)	1 улирал (3 сар)	1 жил (3 улирал)	1 улирал (3 сар)
Сургалтын төлбөр, холбогдох хураамж (нэг улиралд 15 кредит)	12,037.20 ам.доллар	4,012.40 ам.доллар	22,535.55 ам.доллар	7,511.85 ам.доллар	12,850.26 ам.доллар	4,283.42 ам.доллар
Ном, хангамж	600.00 ам.доллар	200.00 ам.доллар	600.00 ам.доллар	200.00 ам.доллар	600.00 ам.доллар	200.00 ам.доллар
Эрүүл мэндийн даатгал	1,174.41 ам.доллар	391.47 ам.доллар	1,174.41 ам.доллар	391.47 ам.доллар	1,174.41 ам.доллар	391.47 ам.доллар
Амьдрах зардал (Айлын гэрт байрлах болон хоол хүнсний зардалд тулгуурлав)	9,861.12 ам.доллар	3,287.04 ам.доллар	9,861.12 ам.доллар	3,287.04 ам.доллар	9,861.12 ам.доллар	3,287.04 ам.доллар
Ойролцоогоор нийт	23,672.73 ам.доллар	7,890.91 ам.доллар	34,171.08 ам.доллар	11,390.36 ам.доллар	24,485.79 ам.доллар	8,161.93 ам.доллар


*Сургалтын төлбөр болон холбогдох хураамжийг Коллеж, Ахлах сургууль, Бакалаврын зэрэгт 15 кредитээр, АХИ-д 18 кредитээр тооцдог.

ОНЦЛОХ ОГНОО


Улирал	Өргөдөл гаргах эцсийн хугацаа	Ирэх/тосож авах огноо	Сургалтын чиг баримжаа олгох долоо хоног	Улирал эхэлнэ	Улирал дуусна
2025 оны зун	Зургаадугаар сарын 9	Зургаадугаар сарын 30	Долоодугаар сарын 2-3	Долоодугаар сарын 7	Наймдугаар сарын 28
2025 оны намар	Наймдугаар сарын 25	Есдүгээр сарын 14-15	Есдүгээр сарын 17-19	Есдүгээр сарын 22	Арван хоёрдугаар сарын 12
2026 оны өвөл	Арван хоёрдугаар сарын 8	Арван хоёрдугаар сарын 29	Арван хоёрдугаар сарын 30-31	2026 оны нэгдүгээр сарын 5	2026 оны гуравдугаар сарын 20
2026 оны хавар	2026 оны гуравдугаар сарын 9	2026 оны гуравдугаар сарын 31	2026 оны дөрөвдүгээр сарын 2-3	2026 оны дөрөвдүгээр сарын 6	2026 оны зургаадугаар сарын 18
2026 оны зун	2026 оны зургаадугаар сарын 8	2026 оны зургаадугаар сарын 29	TBD	TBD	TBD

ЯАГААД EDMONDS COLLEGE-ИЙГ СОНГОХ ЁСТОЙ ВЭ?

Линнвуд, Вашингтон
Сиэтлийн ойролцоо



- Байршил.** Вашингтон муж нь уул нурууд, нуур, далай тэнгис бүхий байгалийн үзэсгэлэн бүрдсэн газруудтай. Технологи, инноваци хурдацтай хөгжиж буй Сиэтл хот нь тус оюутны хотхоноос 25.7 километрийн зайд оршдог. Шинээр ашиглалтад орсон автобусны шугам, найдвартай төмөр зам нь Линнвуд хот дахь манай хотхоныг Сиэтлийн томоохон бүстэй холбодог!
- Нээлттэй элсэлт.** Бүтэн жилийн хугацаанд дөрвөн удаагийн элсэлт авч, англи хэлний түвшин тогтоох шалгалтыг үнэ төлбөргүй өгөх, мөн Англи хэлний институтдээ суралцах боломжийг олгодог тул танд манай элсэлт нээлттэй!
- Санхүүгийн дэмжлэг.** Бид 1000 ам.доллар бүхий шинэ оюутны тэтгэлгийг олгодог бөгөөд олон улсаас шинээр элсэн суралцаж буй оюутнуудад зориулан 500 ам.долларын сургалтын төлбөрийн хөнгөлөлтийг автоматаар олгодог.
- Эрдмийн зэрэг.** Сургалтын 31 хөтөлбөрийг боловсруулан бакалаврын тав, тусгай бүрэн дунд боловсролын 65, мэргэжлийн сертификат олгох 109 сургалт мөн Англи хэлний институтад хамрагдах боломж нээлттэй таныг хүлээж байна!
- Кампусын нөөц.** Манай кампуст хүрэлцэн ирж, цаг хугацааг үр дүнтэй өнгөрүүлснээр оюутан, суралцагчид маань эрдэм шинжилгээний хийгээд мэргэжлийн чиглэл, хувь хүний зорилгоо ойлгон тодорхойлж, үр өгөөжийг хүртэж чаддаг билээ. Оюутны хотхон дотроо 2 дотуур байртай, орчин үеийн ШУТИМ-ийн байртай, оюутанд зориулсан хувийн зөвлөх үйлчилгээтэй, үнэ төлбөргүй сургалтууд явагддаг, хотхон дахь ажлын байрыг бий болгосон, бүтэн жилийн туршид олон арга хэмжээ, үйл ажиллагаанд хамрагдаж, спортоор хичээллэх боломжтой манай эрч хүчтэй хамт олонтой нэгдэхийг урьж байна!



Хүрэлцэн ирээд нүдээрээ хараарай!

Энэхүү QR кодыг уншуулж манай вэбсайт, оюутны хотхон, санал сэтгэгдэл, эх сурвалж болон бусад мэдээлэлтэй танилцах боломжтой.

2+2: ИХ СУРГУУЛЬД ОРОХ ЗАМ

- Өөрийн бакалаврын зэргийн эхний хоёр жилийг дүүргээрэй
- Хамтарсан зэрэг нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - Ерөнхий боловсролын шаардлага
 - Таны их сургуулийн үндсэн мэргэжилд тавигдах урьдчилсан нөхцөл
 - Сонгон суралцах хичээлүүд
- АНУ, Канад, Европ, Азийн бүх их дээд сургуулиудад шилжүүлнэ
- Боломжийн сургалтын төлбөр



Edmonds College-ийн төгсөлтийн баяр



Хамгийн орчин үеийн ШУТИМ болон сувилахуйн барилга байгууламж болох Hazel Miller Hall

МАНАЙД СУРАЛЦАХ ҮНДСЭН ШАЛТГААНУУД

- Сургалтын төлбөр хямд - их дээд сургуулийн 4 жилийн зардлын гуравны нэгээр суралцах боломж
- Шинээр элсэн суралцах бүх оюутан суралцагчдад зориулсан эрт бүртгэл
- Анги дүүргэлтийн тоо цөөн - оюутан нэг бүрд анхаарал хандуулдаг
- Хот хооронд зорчих автобусны хөнгөлөлттэй тасалбар олгодог
- Ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх сургалт, үйлчилгээ үнэгүй
- Ресторан, дэлгүүр лүү алхаад очих зайтай
- Тоглоомын өрөө, биеийн тамирын заал, коллежийн кафэ, нарийн боовны газар, нийтийн ферм бүхий тав тухтай, таатай нөхцөлийг бүрдүүлж чадсан хотхонтой!

ШИЛДЭГ ИХ СУРГУУЛИУД РУУ ШИЛЖИН СУРАЛЦАХ БОЛОМЖТОЙ

Манай оюутан суралцагчид 100% амжилттай шилжин суралцдаг!

- Вашингтоны их сургууль
- Калифорнийн их сургууль
- Миннесотагийн их сургууль
- Индианагийн их сургууль
- Иллинойсын их сургууль, Урбана-Шампэйн
- Аризона мужийн их сургууль
- мөн бусад олон сонголтүүд бий!



Хафиз, Анжел, Кристиал нар бол Америкийн шилдэг их дээд сургуулиудад шилжин суралцсан манай Edmonds College-ийн төгсөгчид юм